

ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙН ХӨГЖИЛД НӨЛӨӨЛЖ БҮЙ МЭРГЭЖЛИЙН ОРЧНЫ БАЙДАЛ

ч. Базар*

* УИХ дахь «Эх орон-Ардчилал» эвслийн бүлгийн ХМА-ны дарга, сэтгүүл зүйн доктор.

Түлхүүр үг: эрэн сурвалжлага, редакцийн хараат бус байдал, сэтгүүлчдийн өөрийн цензур, айдас болгоомжлол, нийтлэлийн болон эдийн засгийн хараат байдал, мэргэжлийн ёс зүй.

Хэдийгээр эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь хэвлэлийн эрх чөлөө буюу хэвлэл мэдээлэл дөрөв дэх эрх мэдэлтэй байгаагийн баталгаа нь болдог ч Монголын сэтгүүл зүйд шинээр орж ирж буй бие даасан төрөл зүйл юм. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь Монголын сэтгүүл зүйд онолын хувьд ч, практикийн хувьд ч шинэ зүйл билээ. Гэхдээ шинэ зүйл гэсэн тодотгол нь энэхүү сэтгүүл зүйн шинж чанарыг өөртөө ямар нэгэн хэмжээгээр хадгалсан сэтгүүл зүйн бүтээл байхгүй гэсэн үг биш билээ. Наяад оны дунд үеэс сэтгүүл зүйд хүчтэй орж ирсэн илчлэн шүүмжлэх чиглэл нь сэтгүүлчдийн үйл явдлыг дагаж, эсвэл хойноос нь мэдээлэх гэсэн идэвхгүй аргыг өөрчилж, сэтгүүл зүй давшингуй байдалд орж, тэр чинээгээрээ нийгмийн сэтгүүл зүйд нөлөөлснийг үгүйсгэх аргагүй юм. Энэхүү илчлэн шүүмжилсэн бүтээл нь Монголын сэтгүүл зүй дэх эрэн сурвалжлах сэтгүүл зүйн таатай хөрс бүрдүүлснийг "...ОНМХ-ийн нийтлэл нэвтрүүлэгт ил тод байдал, олон ургальч шинж нэвтэрч, олон жилийн

турш далд, нуугдмал байдалд байсан сэдвүүдийг хөндөж, ноцтой баримтуудыг илчилж эхэлсэн юм. ...Энэ нийтлэлүүдийн ихэнх нь идэвхтэй сэтгүүл зүйн аргаар бичигдэж, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эх суурийг жинхэнэ ёсоор тавигдахад нөлөөлсөн юм"¹ хэмээн судлаачид зөв зүйтэй дүгнэн хэлсэн байдаг.

Ардчиллын жилүүдэд явуулсан нээлттэй гадаад бодлого, олон улсын барил Монголын сэтгүүл зүйд нэвтэрч эхэлсэн нь эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь нэр томъёо төдийгүй, онол, арга зүйн хувьд танигдан, хөгжих сэтгүүлчийн зарим бүтээл бий болоход түлхэц өгсөн юм. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь ердийн сэтгүүл зүйгээс тэс ондоо зүйл биш бөгөөд энэ сэтгүүлч өөрийн сэжиг таамаг дээр үндэслэн мэдээллийг цуглуулах, баримтыг гүнзгийрүүлэн судлах өвөрмөц арга хэлбэр гэж хэлж болно.

Монголын хэвлэл мэдээллийн хуудаснаа гарч буй нийтлэл мэдээлэлд анализ шинжилгээ хийж, мөн сэтгүүлчдийн дунд тандалт ярилцлага, асуулгын судалгаа явуулж үзэхэд өнөөдөр Монголын сэтгүүл зүйд эрэн сурвалжлах сэтгүүл зүй дөнгөж эхлэл төдий байна гэсэн ерөнхий дүгнэлтэнд хүргэж байна. Өнгөрсөн жил судалгааны ажлын явц дунд Монголын сэтгүүл зүйн хөгжилд нийтлэл бүтээлээрээ тодорхой хувь

нэмэр оруулсан, үе, үеийн чадварлаг 130 сэтгүүлчээс эрэн сурвалжлах сэтгүүл зүйн өнөөгийн байдал, түүнд учирч буй саад бэрхшээл, тулгамдсан асуудлын талаар судалгаа хийж, мэргэжлийн орчин дахь байдлыг тодруулахыг зорьсон юм. "Монголын сэтгүүл зүй дэх эрэн сурвалжлагын өнөөгийн хандлагыг та юу гэж дүгнэдэг вэ?" хэмээн судалгаанд оролцогчдоос асуухад тэдний 95.0 хувь нь эрэн сурвалжлах сэтгүүл зүй дөнгөж эхлэл төдий байна² хэмээн хариулжээ.

Чухам яагаад дөнгөж эхлэл төдий байгаа гэж үздэгээ тэдний 98.0 хувь нь хууль эрх зүйн орчин төгс бус, мөн төдий хувь нь чөлөөт хэвлэл ямар нэгэн бүлэглэл (улс төр, санхүү)-ээс хараат байгаа гэж үзсэн бол сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах эрхийг нь хуульчлаагүй гэж 97.0, хэвлэл мэдээллийн хүчирхэг хэрэгсэл (Үндэсний радио, телевиз) төр, засгийн газрын мэдэлд байгаа гэж 95.0, цензур (редакцийн, төрийн, хууль хяналтын, бүлэглэлийн) хэвээр байгаа гэж 88.5, албан тушаалтан сэтгүүлчдэд мэдээлэл өгч заншаагүй гэж 84.0, сэтгүүлчийн эр зориг дутдаг гэж 80 хувь нь тус тус тайлбарлажээ. Мөн эрэн сурвалжилсан бүтээл хийх эрмэлзэл бүхий, шүүмжлэлт, асуудал дэвшүүлсэн нийтлэл, нэвтрүүлэг ихэвчлэн туурвидаг 30 гаруй сэтгүүлчтэй, мөн тооны сонины эзэн, редактортай тодорхой асуулгын үндсэн дээр тандах ярилцлага хийсний эцэст доорхи дүгнэлт, санааг дэвшүүлэхэд хүрлээ. Энэ нь сонины эзэн, редактор болон эрэн сурвалжлагч сэтгүүлч хоёрын хооронд үүсдэг харилцаа буюу эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр ажиллах сонирхолтой сэтгүүлчдэд учирдаг саад бэрхшээлийг задлан шинжилсэн асуудал болно. Үүнд:

- Сонины эзэн, редактор бодох эргэцүүлэхээс илүү тодорхойлон бичихийг, нөлөөллөөс илүү процессыг эрхэмлэдэг;
 - Сонины эзэн, редактор жижиг сажиг зүй бус явдлын тухай мэдээ, мэдээллийг сониндоо гаргуулдаг мөртлөө нийгмийн тогтолцооны гажуудал эрх мэдэлтнүүдээс хамаатай асуудлыг нийтлэхээс ихэвчлэн татгалздаг;
 - Сонины эзэн, редактор "нийгэм идэвхгүй гөлгөр" байгаагаар шалтаглан, эрэн сурвалжлах ажил хийх нь үр дүнгүй гэж үзэн, тийм санаачилгыг тэр бүр дэмждэггүй;
 - Сонины эзэн, редактор тулгамдсан асуудлыг нуух (хэрүүл, маргаан болохоос болгоомжлон) буюу эсвэл анзаарахгүй дүр эсгэхийг (нийгмийн тусын тулд) хичээдэг;
 - Сонины эзэн, редактор өөрийн нэр төр, албан тушаалд сэв суулгахгүйн тулд хурц асуудлаас тойрч дөлдөг;
 - Сонины эзэн, редактор эрэн сурвалжлах ажил нь эдийн засгийн болон цаг хугацааны эрсдэлтэй гэж болгоомжилдог;
 - Сонины эзэн, редактор реклам, сурталчилгааны орлогоо алдахаас эмээдэг;
 - Сонины эзэн, редактор улс төрийн нам, хүчний гишүүн юмуу түүний нэрийн өмнөөс сонгуульд нэр дэвшиж байсан нь нөлөөлдөг зэрэг нь болно.
- Дээрх тандалтын судалгаанаас харахад эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд хэвлэлийн эздийн тууштай хүсэл эрмэлзлэл сул байгаа нь тодорхой байна. Түүний шалтгаан нь ердөө л хараат байдал билээ. Өөрөөр хэлбэл, хэвлэлийн хараат байдал нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд ихээхэн бэрхшээл авчирч байна. Хэвлэл мэдээллийн хараат бус байдал бол тун адармаатай зарчим бөгөөд энэ нь юуны өмнө сэтгүүлчид мэргэжлийнхээ

ажил үүргийг биелүүлэхдээ аливаа хэлбэрийн нөлөөллөөс ангид байх ёстой гэсэн үндэслэлд тулгуурладаг. Гэтэл бодит байдал дээр хэвлэл мэдээллийг эзэмшигч нь сэтгүүлчийн өдөр тутмын ажилд хөндлөнгөөс оролцож байдаг. Монголын хэвлэлд "Хэрвээ сонин нь биеэ даасан хараат бус юм бол түүнийг эрхлэн гаргаж байгаа хүн ямар ч улс төрийн нам, байгууллагатай холбоо сүлбээгүй байна. Тэрээр хэн нэгэн хүний төлбөртэй захиалгаар түүний таалалд нийцсэн зүйл нийтлэхийг татгалзана" гэсэн чөлөөт хэвлэлийн номлол үйлчлэхгүй байна. Нөгөө талаар олон улс оронд төр, Засгийн газар нь өөрөө хэвлэл мэдээллийн хамгийн том эзэмшигч (ихэвчлэн радио, телевиз) байдаг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл жинхэнэ утгаараа төрөөс хараат бус байх зарчмыг алдагдуулдаг. Хэрвээ Засгийн газар нь өөрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй бол энэ нь зөвхөн өмч эзэмшлийн асуудал байх бөгөөд харин редакцийн бие даасан байдал, нийтлэл, нэвтрүүлгийн бодлогод нөлөөлөх хандлага, үйл ажиллагаа огт байж болохгүй ажээ. Олон улсын практикт үүнийг эрх зүйн хүрээнд баталгаажуулсан байдгийг ч манай улс хэрэгжүүлэх нь зүй ёсны асуудал юм.

Мөн санхүүгийн хувьд хараат байх нь хэвлэл мэдээлэл жинхэнэ утгаараа чөлөөт байж чадахгүйг илэрхийлдэг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл эдийн засаг ба нийтлэлийн

сонирхлыг хооронд нь хатуу зааглаж чадсан тохиолдолд түүний хараат бус байдал хангагддаг ажээ. Хэдийгээр тухайн нийтлэл, мэдээллийг хэвлэн нийтлэх нь түүний бизнест ашиг тустай байлаа ч сонинд хэн нэгний ашиг сонирхлыг бүрэн илэрхийлсэн сурталчилгааны мэдээ, материалыг арилжааны замаар нийтэлсэн тохиолдолд эзэн хүн хэзээ ч сониныхоо нэр хүндийг өсгөж чадахгүй төдийгүй, харин өөрөө хараат болон хувирч буй юм. Хамгийн гол уршиг нь эдийн засгийн

ашиг сонирхол нийтлэл мэдээллийн бодит үнэнийг орхигдуулж байгаад л оршино. Эдийн засгийн сул дорой байдал нь хэвлэл бие даан хөгжихөд бэрхшээл учруулдаг бөгөөд томоохон зар сурталчилгааг байнга нийтлүүлдэг байгууллагууд түүн дээр нь дөрөөлж хэвлэл

лийг хатуу хяналтандаа байлгахыг хичээдэг байна. Засгийн газарт ч энэ байдал ашигтай байдаг бөгөөд санхүүгээр дамжуулан өөрийн нөлөөгөө тухайн хэвлэлд бэхжүүлж авдаг. Өөрийн ашиг сонирхолд үйлчилсэн мэдээ, мэдээлэл бичүүлэхийн тулд улс төр, бизнесийн хүрээнийхэн цалин багатай сэтгүүлчдийг хахуульдах чиглэлээр ч ажилладаг байна.

Үүний зэрэгцээ хараат бус байх нь хэвлэлийн эзний редакцийн бодлогодоо үнэнч байх, сэтгүүлч, редактор мэргэжлийн зарчимдаа туйлбартай байх шаардлагыг хангах замаар тодорхойлогдоно. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь үнэхээр бие

«

Хэрвээ Засгийн газар нь өөрийн мэдлийн ХМХ-тэй бол энэ нь зөвхөн өмч эзэмшлийн асуудал байх бөгөөд харин редакцийн бие даасан байдал, нийтлэл, нэвтрүүлгийн бодлогод нөлөөлөх хандлага, үйл ажиллагаа огт байж болохгүй ажээ. Олон улсын практикт үүнийг эрх зүйн хүрээнд баталгаажуулсан байдгийг ч манай улс хэрэгжүүлэх нь зүй ёсны асуудал юм.

»

даасан, хэн нэгэн эрх мэдэлтэн, тэрбумтан, ямар нэг улс төр, бизнесийн бүлэглэлээс хараат бус оршин тогтнодог бол түүнийг эрхлэн гаргаж байгаа эзэн мөн юунаас ч хамаараагүй байх учиртай. Тодруулбал, тухайн хүн аливаа нэгэн улс төрийн нам, бүлэглэлийн гишүүн бус байхаар барахгүй тэдэнтэй ил, далд холбоо сүлбээгүй байж гэмээнэ түүний хараат бус байдал хангагдана. Тэр бүү хэл ашиг сонирхлын зөрчил бүхий төлбөртэй мэдээлэл нийтлэхээс хүртэл татгалзах ёстой юм.

Энэ бүхнээс харахад Монголын чөлөөт хэвлэлийн хувьд эзний хараат бус байдал алдагдаж, энэ нь сэтгүүлч, ажилтны шударга, үнэнч ажиллах мэргэжлийн зарчимд нөлөөлж, нэг ёсондоо редакцийн хараат бус байдал алдагджээ. Энэ нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд сөргөөр нөлөөлж буй томоохон бодит хүчин зүйл мөн.

Сэтгүүлчдийн дунд явуулсан судалгааны дүнгээс харахад Монголд сурвалжлах сэтгүүл зүй хөгжихгүй байгаагийн өөр нэг бодит шалтгаан нь сэтгүүлчдийн айдас болгоомжлол, тэдэнд учруулдаг дарамт шахалт ажээ. "Та бүхэн яагаад эрэн сурвалжилсан томоохон бүтээл хийхгүй байна вэ? гэсэн асуултанд сэтгүүлчдийн 90.25 хувь амь насанд хохирол учирч болзошгүй, 78.90 хувь нь сэтгүүлчид айдас болгоомжлолтой байна, 90.45 хувь нь редакцийн хамгаалалт баталгаагүй, 85.15 хувь нь сэтгүүлч бичлээ ч сөхөгдсөн асуудал цагдаа, хууль, шүүхийн өмнө очоод замхардаг, 85.0 хувь нь гадны болон эзний дарамт шахалт ирдэг хэмээн хариулжээ. Энэ бүхнийг авилгын хэрэгт холбогдсон УИХ-ын гурван гишүүний хэргийг хянасан прокуро-рын яллах дүгнэлтийг "Сэрүүлэг" сонины сэтгүүлчид их хөдөлмөр гаргаж, хүнд нөхцөлд ажиллаж байж олж аван, улмаар сониндоо

нийтэлсний төлөө ихээхэн дарамт шахалтанд орсон ганцхан жишээгээр тодотгож болно. Энэхүү дарамт шахалт нь манай оронд эрэн сурвалжлах сэтгүүл зүй хичнээн хүнд, ээдрээтэй нөхцөлд байгааг харуулж байна. Судалгаанд өгүүлсэн дээрх шалтгаануудыг задлан үзье.

Сэтгүүлчид эрэн сурвалжлах сэтгүүл зүйн дорвитой бүтээл туурвихгүй байгаагийн нэг гол шалтгаанаа "амь насанд хохирол учирч болзошгүй" хэмээн тайлбарлаж буй нь энэхүү болгоомжлолыг төрүүлэх дотоод шалтгаанаас илүү гадаад буюу олон улсын мэргэжил нэгт нөхдөд нь тохиолдож буй эмгэнэлт үйл явдал нөлөөлж байна гэж үзэх үндэстэй юм. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан 2003 оны 5 дугаар сарын 3-нд буюу дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулсан илгээлтдээ "...сэтгүүлч хүн амиа алдсан тухайн нөхцөл байдал бүрийг бид одоогоор мэдэхгүй байгаа, магадгүй, хэзээ ч олж мэдэхгүй байж болно. Харин дэлхийн өнцөг булан бүрт ажил үүргээ гүйцэтгэж яваад амиа алдсан сэтгүүлч, сурвалжлагчдын ихэнх нь авилгал, хээл хахуулийн хэргийг илчилсэн, хуулийн, эсвэл хууль бус ашиг сонирхолд саад болсон, товчоор хэлбэл мэргэжлийнхээ үүргийг гүйцэтгэсний төлөө хувь хүнийхээ хувьд санаатай аллагын бай болсон гэдгийг Сэтгүүлчдийг хамгаалах хорооны ачаар бид мэдэж байгаа билээ"³ хэмээснээс тодорхой юм. Сэтгүүлчдийг хамгаалах хорооны мэдээлж байгаагаар 2002 оны сүүлчийн байдлаар 136 сэтгүүлч дээрх шалтгаанаар шоронд хоригдсон байна. Монголын сэтгүүлчдийн хувьд гэнэтийн байдлаар амь насаа алдсан тохиолдлууд байгаа ч тэр нь чухам гадны нөлөөтэй эсэхийг тогтоогоогүй байна.

Нөгөө талаар энэхүү айдас болгоомжлол нь сэтгүүлчийн эр

зориг, хүсэл эрмэлзэл дутсантай холбоотой байж болох юм. Нийтийн ашиг сонирхлын үүднээс сэтгүүл зүйд шүүмжлэл, шинжилгээ бүхий мэдээлэл гол байр эзлэх ёстой юм бол, тэр нь нийгмийн удирдлагын эрх ашигт тус нэмэр үзүүлэх, нийгмийг цэвэршүүлэхэд ус агаар мэт хэрэгтэй. Ингэж үзвэл мэдээ, мэдээллийг дамжуулагч сэтгүүлч хүнд эр зориг зайлшгүй хэрэгтэй юм. Ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүлчид шударга ёсыг зөрчсөн үйлдлийг мөрдөн мөшгөх хүсэл эрмэлзэл, ямар ч бэрхшээлтэй тулгарсан түүнийг даван туулах эр зоригтой байж амжилтанд хүрнэ. Тийм тууштай байдал өнөөдөр ажиглагдахгүй байна. Ер нь сэтгүүлчийн айдас болгоомжлол бол хамгийн "харгис" цензур мөн. ОХУ-ын сэтгүүл зүйн нэрт судлаач, доктор, профессор Я.Н.Засурский "өөрийн цензур гэдэг бол тодорхой заавар шийдвэрийг биелүүлэхийг шаардаж буй тодорхой хүчний дарамтаар хийж буй өөрийн хязгаарлалт мөн"⁴ гэж маш оновчтой томъёолсон байдаг. Энэ нь сэтгүүлч хүн өөрөө өөрийгөө хязгаарлах тухай ойлголт бөгөөд эрх мэдэлтний албан тушаалаа урвуулан ашигласан хэрэг, элдэв хуйвалдааны зах сэжүүрээс барьж авсан ч дарамт, шахалтаас болгоомжилж, олон түмний хоточ нохой байх үүргээ өөрөөсөө зайлуулж, түүнийг нуун дарагдуулахад хүргэдэг тохиолдол манайд цөөнгүй байдаг. Энэ утгаараа сэтгүүлчийн айдас болгоомжлол бол сэтгүүлчийн баримтлах "чухал мэдээг нуун дарж болохгүй" гэсэн зарчмаа зөрчин, өөрийгөө хянан цагдаж байгаа үйлдэл юм. Энэ нь тухайн хувь хүнд үзүүлж буй сөрөг үр дагавраас гадна үзэл бодлын ялгаа, зөрчил маргааныг эрүүл бусаар боон дарах хор уршгийг нийгэмд бий болгодог.

Сэтгүүлчид эрэн сурвалжлага хийдэггүй бас нэг шалтгаанаа

редакци сэтгүүлчээ хамгаалж чадахгүй байгаатай холбон үзжээ. Үүнтэй уялдаа бүхий нэг зүйл байгаа нь "эзний болон гадны дарамт шахалт" юм. Редакци сэтгүүлчээ хамгаалж байгааг нэгдүгээрт, шүүхийн өмнө хамгаалах, хоёрдугаарт, эрэн сурвалжилсан бүтээлийг нь нийтэлсэн эсэхээр илэрхийлэгдэнэ. Хэрвээ нэгдэх асуудлын тодотгол нь сэтгүүлчийн хариуцлагатай холбоотой гэж үзвэл харин хоёр дахь асуудлын хамаарал нь редакцын бие даасан байдал болон цензуртэй ихээхэн холбогдож ирнэ. Зах зээлийн чөлөөт өрсөлдөөн нь төрийн дарамтаас илүү шахалтыг хэвлэл мэдээлэлд авчирчээ. "Юу бичихийг зах зээл мэднэ, яаж бичихийг эзэн мэднэ" гэсэн Өрнөдийн зарим орны зарчим Монголын хэвлэлд хүчтэй үйлчилж байна. Дампууралд хүрэхгүйн тулд тухайн хэвлэл мэдээлэлд эзний цензур хүчтэй үйлчилж байна. Өөрөөр хэлбэл, сэтгүүлчийн үзэл бодол, мэргэжлийн эрх нь эзний хяналтаар хязгаарлагдаж байна гэсэн үг. Мөн сонины эзэн эрэн сурвалжлах үйл явц ихээхэн цаг хугацаа, мөнгө санхүү шаарддаг ажил гэдгээр шалтаглан сэтгүүлчдэд урт хугацааны томилолт, түүнд нь тохирсон хөлс мөнгө, мөн гүнзгийрүүлсэн судалгаа хийхэд туслах эдийн засгийн дэмжлэг үзүүлэхээс татгалздаг байна. Мөн ажиллаж буй хэлтэс, тасгийг нь өөрчлөх нэрээр тухайн сэтгүүлчийг халуун цэгээс холдуулдаг арга барил ч эздэд байна.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжихгүй байгаа болон сэтгүүлчид эрэн сурвалжлага хийх хүсэлгүй байдгийн бас нэг шалтгаан нь сөхөж тавьсан болон илчилж мэдээлсэн асуудлын мөрөөр хууль хяналтынхан ажилладаггүй, харин ч цагдаа, хууль, шүүхийн өмнө очоод замхардаг, эсвэл сэтгүүлчдэд буруу нь тохогддоггоор тайлбарлагдах ажээ. Энэ бол үнэхээр ноцтой

бөгөөд бодитой асуудал юм. Үнэхээр эрх мэдэлтнүүдтэй холбоо бүхий мэдээлэл сонин хэвлэлд гардаг ч түүний мөрөөр хууль хяналтынхан хэрхэн ажилласан, ямар хариуцлага хүлээлгэсэн зэрэг нь нийгэмд ил тод мэдээлэгдэхгүй өнгөрөх нь олонтаа байдаг. Нөгөө талаар нэг хэвлэлийн шүүмжлэлт мэдээллийг нөгөө хэвлэл нь эрс няцаасан, хамгаалсан нийтлэл, нэвтрүүлгүүд зэрэгцээд нийтэлчихдэг. Аль нь үнэн, худал болохыг нийгэм ялгаж салгаж чадахгүй байсаар тэдний хараа хяналт суларч, улмаар мартахад хүрдэг. Эцэст нь хүмүүс "энэ сониныхонд итгэх итгэл алга" хэмээн хэвлэлд бурууг өгөөд л орхидог сөрөг зуршил манайд газар авчээ. Тухайлбал казиногийн гэсэн тодотголтой хээл хахуулийн хэргийг илчилж, таслан шийдвэрлэх явцад Монголын сэтгүүлчид, хэвлэл мэдээллийнхэн хэрхэн ажилласан тухай доктор М.Зулькафиль "Сэтгүүлчдийн нэг хэсэг нь үндэслэл, баталгаа нотолгоотой юм ярьж байхад, нөгөө хэсэг нь эрс ондоо зүйл бичиж олон түмнийг төөрөгдүүлж байв. Зарим сэтгүүлчийн бие даасан хараат бус байдал алдагдаж, сэтгүүл зүйн тэнцвэрт байдлыг хадгалах зарчим ихээхэн хэмжээгээр зөрчигдөж байсныг хэлэх хэрэгтэй"⁵ гэсэнтэй санал нэг байна. Миний бодлоор сэтгүүлчдийн энэ байдал илчлэн шүүмжлэх, асуудлыг дэвшүүлэн тавих сэтгүүл зүй ид хөгжиж, нийтлэлийн үр нөлөө нийгэмд ач тусаа өгч эхэлсэн 1980-аад оны сүүл үеэс Монголын сэтгүүл зүйд бодитой орж ирсэн нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд ч ямар нэг хэмжээгээр сөргөөр нөлөө үзүүлсэн юм.

Өөр нэг тулгамдсан зүйл бол мэргэжлийн ёс зүйн талаарх асуудал юм. Олон янзын нөхцөл байдалд ёс суртахууны дэг жаягийг мөрдөн, маргаан, ээдрээтэй асуудлуудыг эрэлхийлэн ажилладагаараа эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь

сэтгүүлчээс мэргэжлийн ёс ихээхэн шаарддаг. Хэрвээ сэтгүүл зүй өөрийн алдаа дутагдалд хариуцлага хүлээх чадвартай юм бол эрэн сурвалжилсан нийтлэл, мэдээллүүд ард түмэнд ямар ач тус үзүүлэх тухай асуулт гарч ирнэ. "Хэн эрэн сурвалжлах мэдээ, мэдээллийг сонирхож байна вэ? Хэрэв хэвлэлийнхэн хүмүүст ташаа хэвлэл хүргэсэн тохиолдолд мэдээлэл хүлээх үү? Энд хэний ашиг сонирхол нөлөөлөх вэ? Хэний эрх, эрх чөлөөнд халдах вэ?" гэх мэт асуултад бодитой хариулж чадвал сэтгүүлч ёс зүйн алдаа гаргахаас сэргийлж чадна. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн маргаантай асуудлууд нь гол төлөв сэтгүүлчийн арга барил, тэр дундаа ташаа мэдээлэл нийтэд түгээсэн зэргээс үүсдэг. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй бодитой хөгжиж чадахгүй байгаагийн нэг шалтгааныг судлаачид "...сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын ур чадвар, ёс зүйтэй холбоотой сул тал байгааг үгүйсгэх аргагүй. Олон нийтийн анхаарал татсан асуудлыг шүүрэн авч, баримт нотолгоогүйгээр шуугиулдаг, улс төрийн зорилгоор хэт нэг талыг барьж бичдэг, аль нэг нам, улс төрийн хүчнийг дарж авах хэрэгсэл болгодог бохир аргаас сэтгүүлчид салж чадаагүй байна. Иймэрхүү бусармаг санаатай нийтлэлийг эрэн сурвалжлах хэмээн ойлгох хандлага ч цухалзах болжээ"⁶ гэж дүгнэсэн байдаг.

Өрнөдийн орнуудад хэвлэлийн ёс зүйг шүүмжлэхийн зэрэгцээ түүнийг тордож байхгүй бол хэтэрхий эрээ цээргүй болж байгааг бүх нийтээр хүлээн зөвшөөрч байсан ч, сэтгүүлчийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд элдэв хязгаарлалт хийх замаар хорих нь эргээд ардчиллын үйлсэд эсрэгээр нөлөөлөх магадлалтайг бодолцож, аль аль эрх ашгийг нь хохироохгүйгээр зохицуулалт хийх арга

зам хайсны дүнд хэвлэл мэдээллийн өөрийгөө зохицуулах системийг бий болгожээ. Өнөөдөр сэтгүүлч нийтлэл мэдээлэлдээ ёс зүйн алдаа гаргасан бол түүнийг мэргэжлийн хамт олны хүрээнд шүүн хэлэлцэх тухай асуудал манай хэвлэл мэдээллийн практикт шаардлагатай зүйл болж байна. Хэрэв Монголд хэвлэлийн консул байгуулагдвал сэтгүүлчдийг буруу ташаа мэдээлэл бичсэн болон бусдын нэр хүндийг гутаасан, доромжилсон нь хэвлэлээр тараагдсных нь төлөө Эрүүгийн хуулиар шийтгэдэг тогтолцоог өөрчилж чадна. Сэтгүүлчийг мэргэжлийнх нь хувьд хамгаалдаг эрх, статустай байгууллага бий болсноор тэдний алдааг хаацайлах бус, харин мэргэжлийн төвшинд залруулж, улмаар хамгаалж, хариуцлага хүлээлгэж чаддаг болгохоор барахгүй сэтгүүлч—олон түмний хоорондын холбоог нягтруулж чадах юм⁷.

Өнөөдөр Монголын чөлөөт хэвлэлийг эрхлэгчдийн өмнө шар хэвлэлийн замаар явах уу, эсвэл нийгэмд нөлөөтэй, нэр хүндтэй, далайцтай хэвлэлийг сонгох уу гэсэн асуудал тулгарч байна. Энэ нь сэтгүүлчийн мэргэжлийн орчинд хариуцлагатай сэтгүүл зүйн асуудал тавигдаж байна гэсэн үг. Хэвлэл мэдээлэл “Шар сэтгүүл зүйн эцэг” гэгддэг У.Херст шиг олны анхаарлын төвд байхын тулд шаардлагатай бол мэдээг зохиож ч болно гэсэн замаар явах уу, аль эсвэл орчин үеийн Америкийн олон түмний сэтгүүл зүй буюу шинэ сэтгүүл зүйг үндэслэгч гэгддэг Ж.Пулитцер шиг “нийгмийн халамжийг сайжруулах, ард түмний

амьдралын төвшинг дээшлүүлэх, тансаг хэрэглээнд өндөр татвар ногдуулах, монополийн эсрэг, авилгад идэгдсэн албан тушаалтнуудыг илчлэн, хариуцлага тооцох, улс төрчид сонгогчдын саналыг худалдан авч байгааг илрүүлэн таслан зогсоох, ажилчдаа албадан санал өгүүлэхийг зогсоох”⁸ зэрэг хөтөлбөр дэвшүүлэн нийгмийн тусын тулд хэвлэл мэдээллийн хүч чадлыг ашиглах уу гэдэг сонголт нь асуудал мөн. Нэр хүндтэй, далайцтай хэвлэл байхын тулд хариуцлагатай сэтгүүл зүйг сонгох тухай яриа хурал,

семинар, симпозиумын хүрээнд сэтгүүлчдийн дунд яригдах болсон нь тэд эрхбиш хоёрдахь замыг сонгожээ гэсэн найдвар өгч байна. Энэ нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төлөвшилтэд ихээхэн ач тустай хэрэг.

Хэвлэл мэдээлэл хариуцлагатай байгаагийн нэг шинж нь хэдийгээр хөдөлшгүй үнэн баримт ч гэлээ түүнийг эргэн нягталж, хэний ч өмнө нотолж чадна гэсэн үедээ сэтгүүлч олон нийтэд мэдээлэх явдал юм. Чухам ганц л баримтыг нягтлаагүйгээс алдах юм бол сэтгүүлчийн зарцуулсан цаг хугацаа, мөнгө санхүү, нэр хүнд, уйгагүй хөдөлмөр алдагдалд орж, харин нийгмийн эрх ашгийг хохироогчдод завших боломжийг өгнө. Өнөөдөр шүүхэд нэхэмжлэл гаргаж буй хувь хүн, байгууллагыг авч үзвэл нийгмийн шүүмжлэлд өртөмтгий хэсэг болох олны дунд алдар цуутай болон өндөр алба хашиж байгаа, эсвэл өмнө нь эрх мэдэлтэй байсан хүмүүс, нийтийн анхаарлын төвд

“

Хэрэв Монголд хэвлэлийн консул байгуулагдвал сэтгүүлчдийг буруу ташаа мэдээлэл бичсэн болон бусдын нэр хүндийг гутаасан, доромжилсон нь хэвлэлээр тараагдсных нь төлөө Эрүүгийн хуулиар шийтгэдэг тогтолцоог өөрчилж чадна

”

байдаг байгууллага, гадаадын дэмжлэг тусламжаар үйл ажиллагаа явуулдаг сан, түүний дарга, захирал, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж ихэнхдээ байна. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн гол обьектууд ихэвчлэн шүүхэд хандаж байгаа нь сэтгүүлчдээс нийтлэл, нэвтрүүлэгтээ хариуцлагатай хандаж, баримтаа нотолж чадах хэмжээнд хүртэл ажиллахыг шаардаж байна гэсэн үг юм.

Энэ мэтчилэн Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн орчин дахь бэрхшээл, сул талыг даван туулж, давуу тал болгох нь зайлшгүй тулгамдсан асуудлууд болж байна.

Ишлэл:

¹ З у л ь к а ф и л ь М. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй: онол, практик, арга зүй. УБ. 2002. Х. 96.

² Судалгааны явцад хийсэн тандалтын судалгаа.

³ "Өнөөдөр". 2003. №156.

⁴ З а с у р с к и й Я. Н. Сэтгүүлчдийн эрх чөлөө, бие даасан байдал: өөрийн цензур, өөрийн хяналт. "Сэтгүүлч". 1996. №1. Х. 9.

⁵ З у л ь к а ф и л ь М. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй: онол, практик, арга зүй. УБ. 2002. Х. 102.

⁶ Н о р о в с ү р э н Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм (гутгаар боть). УБ. 2003. Х. 346.

⁷ Монгол дахь чөлөөт сэтгүүл зүйн зарим асуудал. УБ. 2002. Х. 6.

⁸ "Хэвлэлийн ажиглалт". 2001. №3.

Ашигласан бүтээлийн жагсаалт:

1 З а с у р с к и й Я. Н. Сэтгүүлчдийн эрх чөлөө, бие даасан байдал: өөрийн

цензур, өөрийн хяналт. "Сэтгүүлч". 1996. №1.

2 З у л ь к а ф и л ь М. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй: онол, практик, арга зүй. УБ. 2002.

3 Монгол дахь чөлөөт сэтгүүл зүйн зарим асуудал. УБ. 2002.

4 Н о р о в с ү р э н Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм (гутгаар боть). УБ. 2003.

5 "Өнөөдөр". 2003. №156.

6 "Хэвлэлийн ажиглалт". 2001. №3.

7 К о н с т а н т и н о в А. Журналистские расследования. М. 2002.

8 U l l m a n n J. The Reporter's Handbook an Investiator's Guide to Documents and Techniques. (Third edition). New York 1998.

Resume

A relation occurs between newspaper owner, editor and investigative journalists or the difficulty that faces to investigative journalists who wants to work on investigative journalisms are:

- Newspaper owner and editors prefer to write clearly than to consider on and processes than infection,

- Newspaper owner and editors let to press sensational news but they usually refuse press the deformation of social regularity,

- Newspaper owner and editors think allege by "inactive and smooth society" and the investigative is not successful. Then they don't accept such innovation (enterprising),

- Newspaper owner and editors try to hide the diatribe (to prevent from

- Newspaper owner and editors avoid from sensational problems, because they beware not to blemish on his/her ambition and status,

- Newspaper owner and editors beware that the investigative journalism has economical and time risks,

- Newspaper owner and editors beware to loose income of advertisement,

- Newspaper owner and editors's past participation to political parties elections.

To develop the investigative journalism the weak and unrigid aspiration of newspaper owners looks from this research above. The reason of this is just dependent situation.